**МОНГОЛ УЛС**
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 25 өдөр Дугаар A/257 Мандалговь

“Үндэсний бичиг үсгийн баяр - 2023”
үйл ажиллагааг зохион байгуулахад
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлиг, аймгийн хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1 дүгээр бүлгийн 1.3.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний хэл бичиг, түүнтэй холбогдолтой ёс заншил, өв уламжлалыг судлах, сурталчлах, үндэсний бичгээ чадмаг эзэмших, үр хүүхэддээ зааж өвлүүлэх, олон түмэнд хүртээлтэй их ажлыг өрнүүлэх зорилго бүхий “Үндэсний бичиг үсгийн баяр - 2023” үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсүгэй.

2. Үйл ажиллагаанд зарцуулагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

3. Үйл ажиллагаанд зарцуулагдах 4,670,000 (Дөрвөн сая зургаан зуун далан мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван), Ерөнхий санхүүч (С.Адъяасүрэн) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

4823100686

Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 25 -ны өдрийн А/99 дугаар захирамжийн хавсралт

# “ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯР - 2023” ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ИРГЭД, ХҮҮХДҮҮДИЙН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ УРАЛДААНЫ ТӨСВИЙН ТООЦОО

| № | Уралдаан, сорилын нэр | Оролцогчид | Байр | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ /мян.төг/ | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Төрийн албан хаагчдын "Үндэсний бичгийн мэдлэг сорих сорил" арга хэмжээ | Төрийн албан хаагчид | 1 | 1 | 100000 | 100000 |
| | | | 2 | 1 | 80000 | 80000 |
| | | | 3 | 1 | 60000 | 60000 |
| | | Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нар | 1 | 1 | 100000 | 100000 |
| | | | 2 | 1 | 80000 | 80000 |
| | | | 3 | 1 | 60000 | 60000 |
| 2 | Төрийн албан хаагчдын "Үндэсний бичгийн цахим бичвэр"-ийн уралдаан | Төрийн албан хаагчид | 1 | 1 | 100000 | 100000 |
| | | | 2 | 1 | 80000 | 80000 |
| | | | 3 | 1 | 60000 | 60000 |
| | | Удирлагын ангиалал | 1 | 1 | 100000 | 100000 |
| | | | 2 | 1 | 80000 | 80000 |
| | | | 3 | 1 | 60000 | 60000 |
| 3 | ЕБС-ийн 7-12-р ангийн суралцагчдын дунд үндэсний бичгээр бичих "Уран бичлэг"-ийн уралдаан | ЕБС-ийн 7-8-р анги, 9-10-р анги, 11-12-р ангийн суралцагчид | 1 | 3 | 100000 | 300000 |
| | | | 2 | 3 | 80000 | 240000 |
| | | | 3 | 3 | 60000 | 180000 |
| 4 | Хүүхдүүдийн хоцрогдол арилгах "Монгол хэл, үндэсний бичгийн анги" нийтийн олимпиад | Аймгийн 7, 10-р ангийн 50 бүлгийн 1210 суралцагч | 1 | 2 | 500000 | 1000000 |
| | | | 2 | 2 | 400000 | 800000 |
| | | | 3 | 2 | 300000 | 600000 |
| 5 | Иргэдийн дунд зохион байгуулах "Тээгч, түгээгч" үндэсний бичгийн өдөрлөг арга хэмжээ | Иргэд | 1 | 1 | 100000 | 100000 |
| | | | 2 | 2 | 80000 | 160000 |
| | | | 3 | 3 | 60000 | 180000 |
| | | | Тусгай | 3 | 50000 | 150000 |
| | Нийт дүн | | | | | 4,670,000 |